

ГАДААД БОДЛОГО БА ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ХАРИЛЦАН ХАМААРАЛ

Г. Баасанхүү*

Аливаа улс төрийн бодлогын, тэр дундаа олон улсын харилцаанд нөлөөлөх бодлогын шийдвэр гаргалтын тухай ойлгохын тулд эхлээд *Гадаад бодлогын* тухай мэдлэгээ бататгах ёстой. Хамгийн товчоор гадаад бодлого нь дотоод улс төрийн бодлогын залгамж үргэлжлэл гэж ойлгож болно. Гэвч энэ хоёрын харилцан хамаарлын тухай олон улсын харилцааны онолын сургуулиудад харилцан адилгүй авч үздэг билээ.

Олон улсын харилцааны онолын сонгодог сургуулийнхан болох *реалистууд* гадаад ба дотоод бодлого нь бие биенийхээ хувьд харьцангуй бие даасан байдаг тул нөлөөлөл багатай гэдэг. Жишээ нь Х. Моргентау, гадаад бодлого нь үндэсний ашиг сонирхлоор тодорхойлогддог, үндэсний ашиг сонирхол нь хүний үл хувьсах төрөлх чанартай холбоотой байдаг, газар зүйн хүчин зүйлсээр тайлбарлагддаг, түүхэн уламжлалаар илэрхийлэгддэг. Үндэсний ашиг сонирхлын язгуур нь байнгын чанартай үлддэг тул тухайн улсын дотоод хүчин зүйл, улс төрийн дэглэм, олон нийтийн санаа бодол, засгийн эрх барих хүчний харьцаа зэрэг нь үндэсний ашиг сонирхлыг өөрчилж чадахгүй, энэ утгаар гадаад бодлого нь бие даасан шинжтэй гэж үздэг¹.

Харин *неореалистуудын* хувьд гадаад бодлого нь дотоод бодлогын үргэлжлэл байдаг бөгөөд, гадаад бодлогыг тодорхойлоход шийдвэрлэх үүрэг нөлөөг үндэсний ашиг сонирхол бус, олон улсын харилцааны системийн дотоод хөгжил тодорхойлдог² гэж үзсэнээр аливаа шийдвэр гаргалтанд олон улсын харилцааны системийн бүтцийн өөрчлөлт шийдвэрлэх үүрэгтэй гэсэн сонирхолтой санал, дүгнэлтүүд гаргасныг К.Уолц болон С.Уолт нарын бүтээлээс тодорхой үзэж болно.

* МУИС, ОУХС-ийн багш

¹ Цыганков П.А. *Теория международных отношений*. М.2005, с.30

² Там же., с.31

Гэтэл *неомарксистууд* дотоод бодлогын үндэс нь гадаад шахалт юм гэдэг. Э.Валлерштайн, дэлхийн хөгжингүй цөөхөн улс нь дэлхийн зах хязгаарын нөөцийг ашиглагч эзэнт гүрний төв бөгөөд олон улсын харилцаа нь төв ба зах хязгаар хоорондын тэгш бус харилцааг бүрдүүлж байдаг. Хөгжингүй улсууд энэ харьцааг хэвээр хадгалахын төлөө, зах хязгаарын улсууд энэхүү дэлхийн эдийн засгийн дэг журмыг өөрчлөхийн төлөө гадаад бодлогоор тэмцэлдэж байдаг. Эцсийн дүнд тэдгээрийн үндсэн сонирхол нь гадаад бодлогод нь тусч байдаг бөгөөд хэр амжилттай гадаад бодлого явуулахаас дотоод дахь амжилт нь хамаарч байдаг³. Дотоод улс төрийн амьдралын үйл явц, нам хоорондын тэмцэл дэлхийн эдийн засагт хэр оролцох чадвар, үүргээр нь тодорхойлогдож байдаг гэж үзсэнээр гадаад бодлого нь дотоод бодлогыг тодорхойлдог гэж үздэг байна. Ингэснээр неомарксистууд гадаад бодлого нь дотоод бодлогоос хамааралтай⁴ гэж үздэг марксистуудаас зарчмын ялгаатай байр суурьтай байгаа юм.

Неолиберал онолчид олон улсын харилцаанд олон оролцогчид тоглож, бүрэн эрхт улсууд нь улс хоорондын харилцааны төв байхаа нэгэнт больж, зарим тохиолдолд тусгаар улсгүйгээр олон улсын харилцаа оршиж буй нөхцөлд үндэсний хилийн утга алдагдаж буйн нэгэн адил улс төрийн бодлогыг гадаад ба дотоод гэж ялгах нь утгагүй гэсэн. Тухайлбал, энэ чиглэлийн хамгийн томоохон төлөөлөгчид болох Ж.Най, Р.Кеохэйн нар ингэж үзэж байна.⁵

Юутай ч гадаад болон дотоод бодлого нь хоёул улс төрийн бодлого мөн бөгөөд гадаад бодлого нь дотоод улс төрийн бодлогыг амжилттай гүйцэлдүүлэхээр үйлчилж буй олон улсын дэг журмын хүрээнд авч хэрэгжүүлж байгаа үндэсний бүрэн эрхт улсын олон улсын тавцан дахь бодлого, үйл ажиллагааны цогц гэж тодорхойлж болно. Эндээс харахад гадаад бодлого нь хэдийгээр дотоод бодлогоос урган гарсан шинжтэй боловч харьцангуй бие даасан шинжтэй нь харагдаж байна.

Гадаад бодлого нь хэзээд тухайн улсын хувьд нэн таатай олон улсын нөхцөл байдлыг өөрөөр хэлбэл, гадаад таатай орчныг үүсгэхэд чиглэгдэж байдаг. Ингэж сая засгийн эрхэнд байгаа улс төрийн хүчнүүд өөрсдийн улс төрийн бодлого, зорилгыг амжилттай гүйцэлдүүлэх боломжтой болно.

³ Иммануил Уоллерстейн. *Общественное развитие или развитие мировой системы*. "Вопросы социологии" Т.1 №1 1992, с.77-88

⁴ Маркс К., Энгельс Ф. *Сочинения*. 2-ое издание. Т.12. М.1955, с.735

⁵ Най Дж.С. "Взаимозависимость и изменяющаяся международная политика". "Мировая экономика и международные отношения", 1995. №12, с.81

XIII зууны үед Тэмүүжин хэмээх нэгэн сайн эр гэрийнхээ хойморт тухлан сууж, айргаа шимэн гэрийнхээ үүдээр талд бэлчих адуугаа харан суухдаа дэлхийг байлдан дагуулах сод санаа гаргаагүй нь тодорхой юм. Тухайн үед олон зууны туршид тархай бутархай байсан монгол угсааны овог аймгууд улс төрийн нэгдэлд орон туурга нэг болсны дараа шинээр “тусгаар тогтносон” Монголыг хөрш орнуудаар хүлээн зөвшөөрүүлэх нь Чингисийн улс төрийн бодлогын хамгийн чухал зорилт байсан. Учир нь хөрш орнуудтай хийх худалдаанаас эхлээд тэдэнтэй улс төрийн хувьд найрсаг харилцаатай байх нь шинэ тулгар улсаа байгуулаад байсан нүүдлийн иргэншилтэй монголчуудын хувьд өөрийн улсын бүрэн бүтэн байдлаа хадгалах, эдийн засгаа хөгжүүлэх гадаад чухал нөхцөл байсан бөгөөд харамсалтай нь Монголыг тойрон оршиж байсан ихэнх хөршүүд Чингисийн доор нэгдсэн Монголын “тусгаар тогтнол”-ыг үл тоомсорлож, хүлээн зөвшөөрөөгүй юм. Тухайн үеийн Монголын дипломатын түүхэнд холбогдох баримтуудыг эргэн харвал дээрх саналыг нотолж болно. Чингисийн хувьд шинээр “тусгаар тогтносон” Монголын дотоод эдийн засгийн хөгжилд нэн шаардлагатай гадаад худалдааг хөгжүүлэхэд нэн анхаарч байсан бөгөөд иймдээ ч тухайн үед Зүүн Азийн хөрш орнууд болон Дундад Азийн нөлөө бүхий улсуудад элчин зарж улс төрийн хийгээд худалдааны харилцаа хөгжүүлэх санал олонтоо тавьсан боловч тэдгээр улсууд үл тоомсорлон, басамжилсан байдаг. Энэ талаар Монголын дипломатын түүхч Ж.Бор “Алтан улс Монгол улсыг цэрэг дипломатын даралт шахалтаар өвдөг сөгтгөхийг оролдож ... алба төлөхийг хүртэл шаардаж байжээ. Эл учир Монгол улс зүрчидийн Алтан улстай харилцахдаа улс төр, цэргийн бодлогыг сөргүүлэн тавихад хүрсэн юм.”⁶ гэж дүгнэсэн байхад Хорезм улс Чингисийн элчинг өөртөө худалдан тагнуулаа болгох санал тавьсан, 1218 онд худалдаачдыг нь алж, бараа таваарыг нь дээрэмдсэн учрыг тодруулахаар илгээсэн хоёр удаагийн элчин бүрэлдэхүүнийг хүндлэлгүй эхний удаад доромжлон хөөж, удаах элчин бүрэлдэхүүний ахлагчийг нь алсан зэрэг шалтгаануудаас харахад үнэхээр В.Бартольдийн хэлсэнчлэн “олон улсын харилцааны орчин цагийн зарчмуудаас авч үзсэн ч Чингис Хорезмын эсрэг дайн зарлах бүрэн эрхтэй” байсан бөлгөө.⁷

Удаа дараа элчин зарж гадаад худалдаа хөгжүүлэх санаачлага нь бүтэлгүйтсэн, бусад улсын зүгээс “бүрэн эрхт, тусгаар тогтнол”-ын гол илэрхийлэл гэж үзэж байсан элчингүүдтэй нь зүй бус харилцаж байсан, байнгын дайсагнасан харилцаатай байсан хөрш их гүрний зүгээс “тусгаар тогтнол”-ын баталгааг алдагдуулах дипломат болон

⁶ Ж.Бор. Монголын дипломат товчоон. УБ. 2004, 106-р тал

⁷ В.Бартольд. Туркестан в эпоху монгольского нашествия. Т1. СПб.1900

стратегийн оролдлогууд хийсэн зэрэг нь Чингисийн гадаад улс төрийн бодлогын чиглэлийг үндсэнд нь өөрчилсөн гэж дүгнэж болно. Тэрбээр, шинэ залуу улсынхаа аюулгүй байдал, бүрэн бүтэн байдал хийгээд цаашдын хөгжлийн төлөө Монголыг тойрон орших гадаад орчныг хүчээр таатай болгохоор шийдсэн. Өөрөөр хэлбэл, дотоод улс төрийн бодлогоо амжилттай хэрэгжүүлэхийн тулд хөрш орнуудад хүч хэрэглэх замаар Монголын “тусгаар тогтнол”-ыг хүлээн зөвшөөрүүлэх гадаад бодлогыг явуулж эхлэв.

Хөрш орнуудаар болон бүсийн нөлөө бүхий гүрнүүдээр улсаа хүлээн зөвшөөрүүлэх хүчинд дулдуйдсан гадаад бодлого нь Монгол улс хүчирхэгжихийн хэрээр далайцтай идэвхижиж, анхны зорилгоосоо халин, байлдан дагуулах их гүрний гадаад бодлогын хэв шинжтэй болсон юм.

Нүүдлийн соёл иргэншилтэй Монголын гадаад бодлогод онцгой байр суурийг гадаад худалдаа эзэлж байсныг Монголын дипломатын түүхч Ж.Бор онцолсон байдаг⁸. Үнэхээр нүүдлийн амьдралтай монголчуудын хувьд хөрш суурьшмал иргэншилтэй иргэдтэй хийх худалдаа арилжаа чухал үүрэг гүйцэтгэж ирснийг түүхч Ж.Баясах нотолсон байна.⁹ Хөрш орнуудтай улс төрийн эрх тэгш, эс бөгөөс давуу харьцаатай байснаар гадаад худалдааг хөгжүүлэх, улсын аюулгүй байдлаа хангах боломж бүрдэх байсан тул XIII зуунд монголчууд хүчинд дулдуйдсан гадаад бодлогыг явуулсан гэж дүгнэж болно. Гагцхүү нэгдсэн Монгол улсыг удирдаж байсан Чингис хаан жинхэнэ улс төрийн элит мөн байсан тул эл бодлогыг зөв цэгцтэй явуулснаар амжилтанд хүрч, улмаар хэдхэн жилийн дотор сул дорой байсан Монгол бүсийн их гүрэн болтлоо хүчирхэгжиж, түүнийг залгамжлагчдын үед дэлхийн их гүрэн болж чадсан бөлгөө. Өөрөөр хэлбэл, олон улсын таатай хүрээллийг үүсгэх Монголын гадаад бодлогын амжилтанд “сод бодлоготон”¹⁰ Тэмүжин хэмээх хувь хүний хүчин зүйлсийн нөлөө их байсныг онцлох нь зүйтэй юм.

Түүх хийгээд өнөөгийн улс төрийн нөхцөл байдлаас дүгнэн өгүүлэхэд аливаа улс орон гадаад таатай орчныг үүсгэхийн тулд, өөрт ашигтай олон улсын харилцааны нөхцөл байдлыг үүсгэхээр гадаад бодлого явуулсаар ирснийг харж болно. Энэ нь тухайн улсын засгийн эрхэнд байгаа улс төрийн хүчин, элитүүдийн хувьд өөрсдийн зорилт болгосон дотоод улс төрийн бодлогыг амжилттай хэрэгжүүлэх гол нөхцөл болж байдаг билээ. Орчин цагт дотоод улс төрийн бодлогын зорилтуудыг засгийн эрхийн төлөө өрсөлдөгч улс төрийн

⁸ Ж.Бор. Монгол хийгээд Евразийн дипломат шастир. Иботь, УБ.2004, 436-440-р тал

⁹ Ж.Баясах. Их Монгол улсын түүхэнд холбогдох хятад хоёр сурвалж бичиг. УБ. 2005.

¹⁰ Ж.Бор. Эгэл, эгэл бус өнө мөнхийн Чингис хаан. УБ. 2005 он. 38-84-р тал

хүчнүүдийн сонгуулиар дэлгэн сурталчлах мөрийн хөтөлбөрөөс тодорхой харж болно. Улс төрийн намуудын мөрийн хөтөлбөр нь үндсэндээ засгийн эрхэнд гарвал төрийн бодлого болгон авч хэрэгжүүлэх тухайн намын улс төрийн бодлогын зорилтууд байдаг юм. Хичнээн дотоод эдийн засаг болон улс төрийн таатай нөхцөл байдал бүрэлдсэн ч гадаад орчин таагүй байвал засгийн эрхийг баригчид өөрсдийн зорилго буюу улс төрийн бодлогоо хэрэгжүүлэх боломжоо алдаж эхэлдгийг дээр дурдсан Чингисийн дайнч гадаад бодлогын шалтгаанаас харж болно. Учир нь гадаад бодлого тухайн улсын тусгаар тогтнол, бүрэн бүтэн байдалд нөлөөлж байдаг билээ.

Өөрөөр хэлбэл, гадаад таатай орчныг үүсгэхээр чиглэгдэж байгаа улс төрийн бодлого тухайн улсын оршин тогтнолын илэрхийлэл болсон бүрэн эрхийн зарчимтай шууд холбогдож байдаг. Эл хүрээнд гадаад бодлогын үндэс нь зайлшгүй тухайн улсын ашиг сонирхол байдаг гэсэн үг юм. Үндэсний ашиг сонирхол буюу *үндэсний эрх ашиг* хэмээх ойлголт хэзээд байсаар ирсэн бөгөөд энэ талаар Күнз, Фукидидээс эхлэн үеийн суутнууд дурдсаар ирсэн ба харин үндэсний ашиг сонирхол нь тухайн улсын гадаад бодлого, цаашлаад олон улсын харилцаатай шууд холбогддог гэдгийг онолын хувьд нотолсон эрдэмтэн бол Ханс Моргентау юм*. Түүний үндэсний ашиг сонирхлын онол хэдий шүүмжлэлд өртсөөр ирсэн боловч өнөөдрийг хүртэл хүлээн зөвшөөрөгдсөөр байгаагийн гол шалтгаан нь олон улсын харилцааны голлох тоглогчид нь бүрэн эрхт улсууд хэвээр байгаагаар шууд холбоотой юм. Хэдийгээр даяаршлын нөлөөгөөр үндэсний ашиг сонирхлын бүтцэд өөрчлөлтүүд орж байгаа боловч түүний агуулга өөрчлөгдөөгүй л байна. Иймд аливаа улсын гадаад бодлогод анализ хийх хамгийн эхний шат нь тухайн улсын ашиг сонирхлыг зөв тодорхойлох судалгаа гэж болно. Аливаа ашиг сонирхлын үзүүрт хэзээд хэрэгцээ оршдог. Ашиг сонирхол нь нэг зэрэг бодит ба хийсвэр шинжтэй юм. Учир нь хэрэгцээ бүр үнэн байхаас гадна, нэг зэрэг худал ойлгогдсон сонирхол гэж байж болно. Энэ утгаар гадаад бодлогын шийдвэр гаргалт амжилттай байх нэгэн чухал нөхцөл нь шийдвэр гаргагчид үндэсний эрх ашгаа зөв ухаарах, судлаачид зөв үнэлэн дүгнэх явдал билээ.

* "Үндэсний эрх ашиг" ба "үндэсний ашиг сонирхол" хэмээх нэр томъёо нь угтаа нэг л ухагдахуун болох тухайн улсын оршин тогтнол, бүрэн бүтэн байдлыг хангах явдлыг илэрхийлдэг. Энэхүү өгүүллийн хүрээнд гадны судлаачдын "national interest" хэмээх нэр томъёог шууд орчуулсан "үндэсний ашиг сонирхол" хэмээх нэрийдлийг голлов. 1994 оны "Монгол улсын Гадаад бодлогын үзэл баримтлал" болон бусад баримтуудад "үндэсний эрх ашиг" хэмээсэн байдаг нь угтаа монгол хэлний маань баялаг өвийн агуулга нотолж байдаг бөлгөө. Бидний санахад "үндэсний эрх ашиг" хэмээх нэр томъёогоор тухайн улсын мөнхийн ашиг сонирхлыг, харин "үндэсний ашиг сонирхол" хэмээх нэр томъёогоор хувьсах, хоёрдогч ашиг сонирхлыг илэрхийлэх нь зөв мэт.

Гэвч улс төрийн реализмын томоохон төлөөлөгч Раймон Арон үзэхдээ үндэсний ашиг сонирхол нь улс төрийн лидерүүдийн шийдвэрүүдийг тодорхойлдоггүй бөгөөд харин ч шийдвэр гаргагч этгээдүүд өөрсдийн шийдвэр, бодлуудыг үндэсний ашиг сонирхол болгон тулгадаг гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, тэрбээр, аливаа улсын гадаад бодлого нь зорилгыг тодорхойлох эрх чөлөөтэй улстөрчдийн үйл ажиллагаагаар илэрч байдаг гээд энд үзэл суртал, хувийн амбици, сэтгэл хөдлөл зэрэг шийдвэрлэх үүрэгтэй гэсэн¹¹. Тэрбээр үндэсний ашиг сонирхол гэдэг нь бодитой боловч таних аргагүй зүйл гэж үзсэн байдаг нь ортой юм.

Хэдий Фукидидээс эхлэн Моргентауг хүртэл түүхэн сэтгэгчид үе үед тусгаар улсын үйлдэл, гадаад бодлогын зорилго, тэр дундаа ашиг сонирхлыг тайлбарлахыг оролдсоор ирсэн ч онолын бүрэн шийдэлд хүрээгүй байгаа нь үндэсний ашиг сонирхол таних аргагүй бас нэгэн шинжийг өөртөө агуулж байдгийн нотолгоо мөн гэлтэй.

Үндэсний ашиг сонирхол нь олон улсын тавцан дээр тухайн улсын үүрэг ролийг хадгалах, бүс нутаг, олон улсын тогтвортой байдлыг бататгаж, бодит аюулыг арилгах явдал байдаг гэж үзвэл, тусгаар улсын хувьд ихэнхдээ ахадсан шинжтэй дээрх зорилтуудыг гүйцэлдүүлэх боломжоор нь урт, дунд, богино хугацааны гэж цаг хугацааны хувьд тавигдсан төлвөөр гурав хуваан авч үзэж болно.

Эцэст нь үндэсний бүрэн эрхт тусгаар улсын язгуур эрх ашиг нь цэргийн аюулгүй байдал, эдийн засгийн цэцэглэлт хөгжилт, олон улсын тааламжтай аюулгүй хүрээлэл байдаг гэсэн нийтлэг зарчим дээр тулгуурлан авч үзвэл улс орнуудын гадаад бодлогын зорилгыг тодорхойлохдоо нэн түрүүнд үндэсний ашиг сонирхлыг нь эрэмбэлэн судлаж үзэх нь чухал болж байна.

Монгол улсын үндэсний эрх ашгийг байнгын болон хувьсах шинж чанараар нь үнэлэн үзвэл, хүчирхэг хоёр гүрэнтэй хил залгадаг, Умард Солонгосын цөмийн хөтөлбөр, Солонгосын хойгийн асуудал, Эх газрын Хятад ба Тайваний асуудал, Япон ба ОХУ-ын газар нутгийн асуудал зэрэг улс төрийн олон тооны зөрчилтэй, цэрэг стратегийн хүчний их хэмжээний төвлөрөлтэй бүс нутагт харьяалагдаж байгаа манай улсын хувьд эх орноо хамгаалах нь зайлшгүй ашиг сонирхол бол, хөгжиж байгаа бага жижиг улсын хувьд эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахын тулд хандивлагч орнуудын дэмжлэг, ялангуяа гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламж зэрэг эдийн засгийн тааламжтай нөхцөл байдал мөн л зайлшгүй ашиг сонирхол болоод байгаа юм. Жижиг улсын хувьд

¹¹ Цыганков П.А. Теория международных отношений. М.2005, с.292

олон улсын харилцаа тааламжтай байх нь маш чухал шинжтэй тул, Монголын хувьд хүлээн зөвшөөрч байгаа нэг туйлт дэлхийн дэг журмыг цаашид ч дэмжих замаар эдийн засгийн тусламж, улс төрийн дэмжлэг, стратегийн баталгаа олж авах нь бодит ашиг сонирхол мөн. Дэлхийн хөгжлийн чиг хандлага даяаршлаар тодорхойлогдож, улс үндэстэн, хил хязгаарын зааг ялгаа арилж байгаа орчин цагийн нөхцөл байдалд харилцан хамаарал өсөн нэмэгдэхийн хэрээр бага улсын хувьд үндэсний оршин тогтнолоо хангах, үндэсний аюулгүй байдлын үүднээс өөрийн давтагдашгүй монгол үндэстний уламжлалт үнэт зүйлсийг хадгалах нь тулгамдсан хувийн ашиг сонирхол мөн.

Ингэж үзвэл гадаад бодлогын судалгаанд зорилгыг тодорхойлоход үндэсний ашиг сонирхлыг нь зайлшгүй тооцон үздэг байна. Ингэхдээ үндэсний эрх ашигт багтах олон тооны зорилтуудыг тулгамдсан шинжээр нь, ялгавартайгаар зөв тодорхойлон ухаарах нь хамгийн чухал ажээ.

Нөгөөгүүр үндэсний ашиг сонирхол нь гадаад бодлогын зорилгыг тодорхойлж байдаг тулгуур ухагдахуун, зарчмууд мөн боловч үндэсний ашиг сонирхлын бүтцэд ухамсаргүй элементүүд оршин байдгийг судлаачид нэгэнт хүлээн зөвшөөрөх болов. Жишээ нь, Монголын гадаад бодлогын түүхийг эргэн харвал бүхэлдээ өмнөд хөршөөс зайгаа барьсан, хятадуудад дургүйцсэн өнгө аяс ажиглагдаж байдаг. Энэ нь түүхэн улс төрийн нөхцөл байдлаар Хятадын төрт улсууд хүчирхэгжих тоолондоо дайнч монголчуудыг өөрийн харьяандаа багтаахыг, тархай бутархай, сул дорой байлгахыг оролдсоор ирсэнтэй уялдан монгол үндэстний сэтгэл зүйд хятадуудад таагүй, хөндий хандах сэтгэл зүй төлөвшсөнтэй холбоотой юм. Хэрвээ ашиг сонирхол нь хэзээд ухамсарласан, ухаарсан хэрэгцээ байдгаа гэж үзвэл улс төрийн бодит зорилгод үл хамаарах мөнхийн зорилгыг тухайлбал, улс үндэстний өөрөө өөрийгөө хамгаалах, өөрийгөө сэргээх ухамсраас ангид чадварыг агуулж байдаг. Өөрөөр хэлбэл, үндэсний ашиг сонирхол нөгөө талаас ухамсаргүй элементүүдийг агуулж байдаг нь харагдаж байна. Зүй нь, Монголын үндэсний ашиг сонирхлын ухамсаргүй элементийн нэг тод илрэл нь өмнөд хөрш БНХАУ-д хандсан болгоомжилсон өнгө аяс бөлгөө.

Оросын эрдэмтэн Межуев.Б.В ихэнхдээ улс орнуудын улс төрийн чиглэл нь идеал буюу хийсвэр байдлаар үндэсний ашиг сонирхолд нийцээд, харин бодит байдал дээр материаллаг байдлыг тусгаж байдаг гэж үзсэн¹².

¹² Межуев Б.В. Моделирование понятия "национальный интерес". На примере дальневосточной политики России конца XIX-начала XX в//Полис. 1999. №1, с.26

Бид хэдийгээр Монгол улсын мөнхийн эрх ашгийн хүрээнд өмнөд хөршөөс болгоомжилсон бодлого явуулсаар ирсэн боловч, ардчилсан улс төрийн тогтолцоо, зах зээлийн эдийн засагт шилжих хүнд үеийн нөхцөл байдлаас шалтгаалан үндсэндээ Монголын гадаад бодлогод мөнхийн үндэсний эрх ашгийн зорилтоос илүүтэй, цаг хугацааны шинж чанартай бодит ашиг сонирхлуудаа гүйцэлдүүлэхийг урьтал болгосоор ирснийг 1992 оноос хойшхи манай улсын эдийн засагт хүч түрэн орж ирж байгаа Хятадын хөрөнгө оруулалтын нөлөө, манай улсын өргөн хэрэглээний зах зээлийг байлдан дагуулсан Хятадын бараа бүтээгдэхүүнүүд, Монгол улсын хөгжлийн дүр зураг болоод байгаа хятад барилгачдын барилга, орон сууц зэргээс харж болно.

Нөгөө талаас гадаад бодлогын зорилгод олон улсын харилцааны нөхцөл байдал нөлөөлж байдаг болохыг неореалистууд болон модернистууд тодотгон авч үзсэн байдаг.

Жеймс Розенау өөрийн гинжин холбооны онолын хүрээнд аливаа улсын гадаад бодлогод гадаад хүчин зүйлс болон түүнээс илүү улс төрийн удирдагчийн авьяас, хувийн зан чанар, Засгийн газрын бүтэц, нийгмийн байдал, үндэстний эв нэгдлийн түвшин зэрэг дотоод хүчин зүйлс нөлөөлдөг гэж үзсэн. Энэ утгаар модернистууд болон постмодернистуудын судалгааны үндсэн анхаарал нь олон улсын харилцааны субъектив тал буюу хувь хүмүүсийн болон бүлэг хүмүүсийн шийдвэр гаргалтанд ханддаг байна.

Харин неореалистууд гадаад бодлогод нөлөөлөх гол хүчин зүйлс нь гадаад орчны нөлөөлөл буюу үйлчлэн байгаа олон улсын харилцааны системийн нөлөө байдаг гэж үздэг. Үнэхээр дэлхийн тусгаар бүрэн эрхт 200 гаран улсын дийлэнх олонхи буюу $\frac{2}{3}$ нь жижиг улс гэсэн ангилалд хамрагдаж байдаг бөгөөд тэдний хувьд өөрийн аюулгүй байдлаа хангах, ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх боломж, гадаад бодлогын чадавхиасаа хамааран дасан зохицсон буюу статус-кво хэв шинжийн гадаад бодлогыг явуулдаг. Энэ нь орчин цагт прагматик гадаад бодлогын хувилбараар илэрч байдаг гэж үзэж болно. Жишээ нь, Монгол улсын 2000 оноос хойшхи гадаад бодлогын үйл ажиллагааны чиглэлийг харахад прагматик хувилбартай бодлого явуулж байгаа нь харагддаг.

Олон улсын харилцаанд 2001 оны 9 сарын 11-ний хэргээс хойш нэг туйлт систем үйлчилж эхэлсэн нь АНУ-ын санаачилсан терроризмын эсрэг дайнаар хэрэгжиж эхэлсэн.** Хэдийгээр Монгол улсын хувьд АНУ-тай ашиг сонирхлын зөрчилтэй Орос, Хятад хоёр гүрэнтэй хил залгах геополитикийн хавчигдмал байршилтай, хоёр хөршөөсөө

** Энэ талаар судлаачийн "Стратеги судалгаа" сэтгүүлийн 2006 оны №1/33-д гарсан "Олон улсын харилцааны түүхийг үечлэх асуудалд" өгүүллийг үзнэ үү.

түүхий эд, дэд бүтэц, эдийн засгийн хараат байдалтай, хөгжиж байгаа жижиг улс хэдий ч терроризмын эсрэг дайныг анхнаас нь идэвхтэйгээр дэмжин, АНУ-ын байр суурийг талархан дэмжиж, Терроризмын эсрэг эвсэлд нэгдсэн нь прагматик бодлого явуулж байгаагийн тод илрэл байсан. Тухайн үед хурц шүүмжлэлд өртөж байсан ч Монгол улсын Засгийн газрын байр суурь, сонгосон стратеги оновчтой байсан нь АНУ-ны Ерөнхийлөгч Ж.Бушийн Монголд хийсэн айлчлал, олон улсын тавцан дээр Монголын нэр хүнд өссөн үзүүлэлт, Мянганы сорилын санд Монгол улс багтсан зэрэг үйл явдал нотолно. Нөгөө талаар Монгол улсын гадаад бодлого нь олон улсын харилцааны бүтцийн нөлөөг зөв тооцон тогтвортой манлайлагч АНУ-ыг идэвхтэй дэмжсэнээр амжилт олсноос гадна, эл гадаад бодлогын үйл ажиллагаагаараа дамжуулан хоёр хөрш орны Монгол улсад хандах хандлага, улс төрийн сонирхлыг өсгөж өгсөн давхар ач холбогдол бүхий прагматик гадаад бодлого мөн юм.

Дүгнэвэл, аливаа бүрэн эрхт улсын гадаад таатай орчныг үүсгэхээр чиглэгдсэн гадаад бодлогын зорилго нь үндэсний эрх ашгаар илэрч байдаг бөгөөд нэг улсын ашиг сонирхол нөгөөгийн ашиг сонирхлыг алдагдуулж, аюулгүй байдлыг хөндөж байдгаас гадаад бодлогын зөрчил олон улсын харилцааг тодорхойлж байдаг.

Улс орон бүр эдийн засгийн хөгжлийн түвшин, цэрэг-стратегийн түвшин, улс төрийн нөлөө зэргээрээ ялгагдан, ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх харилцан адилгүй боломжтой байдгаас гадаад бодлогын чадавхийн ялгаа үүсдэг. Энэ нь улс орнуудыг өөрийн аюулгүй байдлаа хангах, ашиг сонирхлоо гүйцэлдүүлэхийн төлөө арга боломжоо байнга нэмэгдүүлэхэд хүргэдэг. Ялангуяа гадаад бодлогын энхийн ба хүчний арга хэрэгслүүрээс, хүчний арга боломжоо нэмэгдүүлэхийг эрмэлздэг. Ингэснээр ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх бүрэн чадавхитай голлох оролцогчид болох их гүрнүүдийн хооронд хүчний тодорхой харьцаа үүсдэг. Ашиг сонирхлоор илэрхийлэгдсэн гадаад бодлогын зорилгоо гүйцэлдүүлэх арга хэрэгслүүрийн сонголтыг стратеги гэх бөгөөд гадаад бодлогын үйл ажиллагаа нь стратегийн хүрээн дэх зорилгын хэрэгжилт байдаг юм. Гадаад бодлогын стратеги нь хэрэгжих боломжоороо хугацааны ялгавартай байдаг бөгөөд урт хугацааны, дундын, ойрын байж болно.

1994 онд УИХ-аас батлан гаргасан “Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал” нь урт хугацааны стратеги бол АНУ болон хөгжингүй улс орнуудаас улс төр, эдийн засгийн идэвхтэй дэмжлэг авч гадаад бодлогын урт хугацааны стратегиа хэрэгжүүлэх чадавхитай болох нь дунд хугацааны, харин улс төрийн намуудын мөрийн

хөтөлбөрийн хэрэгжилт буюу Засгийн газрын нийгмийн бодлого болоод байгаа төрөл бүрийн нийгмийн халамж, тэтгэлгийн гол эх үүсвэр болсон үндэсний эдийн засгийг хөгжүүлэх гадаадын хөрөнгө оруулалтыг ихээр татах нь ойрын стратеги байх жишээтэй. Гадаад бодлогын зорилгоо хэрэгжүүлэхээр сонгосон арга хэрэгслүүрийн сонголтоос хамааран олон улсын тавцан дахь тухайн улсын үйл ажиллагаа нь дипломат яриа хэлэлцээнд тулгуурласан хамтын ажиллагаа, эс бөгөөс хүчинд тулгуурласан цэргийн стратегиас үүдэлтэй бусадтай зөрөлдөх зөрчил байж болно.

Гадаад бодлогын стратегийг хэрэгжүүлэх тодорхой нэг үйл ажиллагааг гадаад бодлогын тактик гэж үзвэл Монгол улсын терроризмын эсрэг АНУ-ын байр суурийг дэмжсэн улс төрийн мэдэгдэл, Терроризмын эсрэг эвсэлд нэгдэн хилийн чанадад монгол цэргийн бие бүрэлдэхүүнийг илгээсэн (Зөвхөн Иракт нийт 9 ээлж энхийг сахиулах хүчнийг илгээгээд байна), АНУ-ыг гуравдагч хөршөөрөө зарласан зэрэг нь гадаад бодлогын тактик байсан. Харин эдгээр тактикуудын дүнд АНУ-ын улс төр, эдийн засгийн урт хугацааны дэмжлэгийг олох гэсэн Монгол улсын гадаад бодлогын стратеги хэрэгжсэн гэж үзэж болно. Монгол улсын гадаад бодлогын зорилгын хэрэгжилт дан ганц манай улсын үйл ажиллагаагаар хэрэгжихгүй.

Нөгөө талаас АНУ-ын засаг захиргаа Монгол улсын баримталж байгаа байр суурийг үнэлэн үзэж Мянганы сорилын санд багтаан, Ерөнхийлөгч нь манай улсад айлчлан, батлан хамгаалах салбарт үзүүлэх бодит тусламжаа нэмэгдүүлэхээр амлаж байгаа, Монголын гуравдагч хөршөөр өөрийгөө хүлээн зөвшөөрсөн зэргээр терроризмын эсрэг эвслээ өргөжүүлэх стратегийн хүрээнд Монгол улстай идэвхтэй хамтын ажиллагаа өрнүүлсэн гадаад бодлогын үйл ажиллагаа явуулж байгаа нь Монгол улсын АНУ-ын дэмжлэгийг хүртэх үйл ажиллагаатай холилдон олон улсын үйл явдал болж байгаа юм.

Монгол-Америкийн харилцаа терроризмын эсрэг эвслийн хүрээнд улам дотносохын хэрээр хөрш ОХУ, БНХАУ-ын болгоомжлол өсөн нэмэгдэж, Монгол улстай найрсаг харилцаатай бүх улсууд манай гуравдагч хөрш гэж мэдэгдэхэд хүргэх улс төрийн шахалт үзүүлсэн, жижиг хөршөө ахин идэвхтэйгээр сонирхож эхэлсэн зэрэг нь Монгол улсыг тойрсон олон улсын улс төрийн үйл явдлыг өрнүүлж олон улсын үйл явц болгож байна.

Монголыг сонирхсон их гүрнүүдийн ашиг сонирхлын зөрчил, их гүрнүүдийн гадаад бодлогын зөрчил дээр тоглох манай улсын гадаад бодлогын стратеги нь олон улсын тодорхой асуудлыг үүсгэх боломжтой бөгөөд нэг талаас олон улсын харилцаанд

тогтвортой манлайлагч АНУ, нөгөө талаас хоёр их хөршийг зэрэг хянах геополитикийн таатай байршилд байгаа Монголыг Америкийн нөлөөнд болон харилцан нэгэндээ алдахгүй байх Хятад, Оросын эрмэлзэл нь хүчний харьцааг өөрчлөх хөгжлийг дагуулах боломжтой. Эл нөхцөлд Монгол хэр чадварлаг тоглохоос манай улсын гадаад бодлогын урт хугацааны стратегийн хэрэгжилт шууд шалтгаалж, хэрвээ өөрт ашигтай байдлаар хүчний харьцааг өөрчилж чадвал олон улсын улс төрийн шинэ нөхцөл байдлыг үүсгэнэ.

Ийн улс хоорондын гадаад бодлогоор өрнөх улс төрийн харилцаа нь цикл байдлаар тасралтгүй хөгжиж байдаг байна. Өөрөөр хэлбэл, гадаад бодлогын нэг зорилгын хэрэгжилтийн явц, шийдэл нь дараагийн зорилгыг үүсгэж байдаг.

Олон улсын тавцан дахь тухайн улсын үүрэг ролийг хадгалах, бүс нутаг, олон улсын тогтвортой байдлын баталгаа олох, бодит аюул заналыг арилгах зэрэг нь үндэсний ашиг сонирхол байдаг гэж үзвэл өөрийн улсад гадаад таатай нөхцөл байдлыг хангах, улсынхаа үндэсний эрх ашгийг хамгаалах, зөрчлийг арилган олон улсын найрсаг уур амьсгалыг бүрдүүлэх гол хэрэгслүүр бол гадаад бодлого юм.

Энэ утгаар гадаад бодлого нь аливаа улсын олон улсын харилцаанд хандсан тодорхой чиглэлийн үйл ажиллагаа бөгөөд бусад улстай харилцахдаа өөрийн үндэсний ашиг сонирхлыг таниулан гүйцэлдүүлэх арга хэрэгслүүр мөн.